



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цоожэд өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/03/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: С.Цэдэнлхам
Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.13 № 315

танай _____ ны № _____ т

"ЦООЖЭД" ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ц.ӨСӨХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Цоожэд" өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Цоожэд" өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагчлалын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх журамд заасны дагуу маргадлан итгэмжлүүлж, хоёр жилийн хугацаатайгаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Өрхийн эрүүл мэндийн төв нь сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба тайлант онд 479.9 сая төгрөгийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж, 474.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 5.6 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан

гэрээ байгуулж 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын 55 арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	77,053.8	47,808.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	251,600.7	263,374.5
	Нийт хөрөнгийн дүн	328,654.5	311,182.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	328,654.5	311,182.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	328,654.5	311,182.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	544,612.2	580,638.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	520,073.9	597,230.2
	Үйл ажиллагааны үр дүн	24,538.3	(16,591.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(880.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	24,538.3	(17,471.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	307,950.2	328,654.5
	Тайлант оны үр дүн	20,704.3	(17,471.7)
	Эцсийн үлдэгдэл	328,654.5	311,182.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	460,421.8	555,176.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	458,718.2	548,041.8
	Үйл ажиллагааны ЦМГ	1,703.6	7,134.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(10,690.0)	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(8,986.4)	7,134.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,899.6	3,913.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,913.2	11,048.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	469,408.2	548,041.8
	Урсгал зардал	458,718.2	548,041.8
	Хөрөнгийн зардал	10,690.0	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	460,421.8	555,176.7
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	435,527.8	509,448.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,724.0	25,000.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас (бусад)	140.0	20,728.6
	Хандив тусламж (дотоод)	30.0	

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цоожэд өрхийн эрүүл мэндийн төвийн зорилго нь Өрхийн эрүүл мэндийн төв нь хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Цоожэд БГБХ нөхөрлөл статустай байна. Нөхөрлөл нь хувьцаа эзэмших 6 гишүүнтэй, гишүүн бүр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй, удирдах эрх бүхий гишүүнийг олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна гэж гэрээнд заасан байна.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар
- Булган аймгийн 2025 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх журамд заасны дагуу маргадлан итгэмжлүүлж, хоёр жилийн хугацаатайгаар баталгаажуулсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээ байгуулж 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын 55 арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Өрхийн эрүүл мэндийн төв нь сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба тайлант онд 479.9 сая төгрөгийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж, 474.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 5.6 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар

зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цоожэд өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх мэдээллийг тухай бүр нь мэдээлж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, биелэлтийг гаргаж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

